

3.1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэх, арга зүйн зөвлөмж болгон хэрэглэх санаачлагыг дэмжих.

**Хүрэх үр дүн:** Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагаа төлөвшсөн байна.

#### **Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, санхүүжилт**

4.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг холбогдох байгууллага үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнджил бүр тусган хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн талаарх тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн түвшинд удирдан зохион байгуулах үүргийг Засаг даргын Тамгын газар аймаг, салбар зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ. Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага энэ хөтөлбөрийн хүрээнд өөрт хамаарах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

4.4. Аж ахуйн нэгж, байгууллага бүр энэхүү хөтөлбөрт тусгагдсан холбогдох асуудлыг жил бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

4.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- улсын болон орон нутгийн төсөв.
- олон улсын байгууллага, болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт.
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулах хөрөнгө.
- бусад эх үүсвэр.

#### **Тав. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ**

5.1. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ажилтны болон ажил олгогчийн төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ил тод, нээлттэй мэдээлнэ.

5.3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний зөвлөлд хүргүүлнэ.